

Сурагч Дэмжих Баг (SST)-н Хурал: Гэр бүл/Асран Хамгаалагчдын Мэдлэгт

Сурагчийн нэр:

Date:

Сурагч Дэмжих Баг (SST) гэж юу вэ?

SST нь сурагчдын сурлагын, нийгэм/сэтгэл хөдлөлийн, зан төлөв болон/эсвэл сургууль дээр дасан зохицох чадварын талаар дүгнэлт гаргах олон мэргэжлийн гишүүдээс бүрдсэн баг юм.

SST баг ямар гишүүдээс бүрдэх вэ?

Та эцэг эх/асран хамгаалагчийн хувьд **эрх тэгш** багийн гишүүн бөгөөд мөн эдгээрт ерөнхий эрдмийн багш, тусгай боловсролын багш, сургуулийн удирдлага (ихэвчлэн "LEA" гэж нэрлэдэг - орон нутгийн боловсролын агентлагийн төлөөлөгч), сургуулийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан болон сургууль болон/эсвэл гэр бүлээс урьсан бусад хүмүүс багтана. Та уулзалтад оролцохыг хүссэн хүнээ урьж болно.

Юу хэлэлцдэг вэ??

- Сурагчийг санал болгосон хүний (эцэг эх/асран хамгаалагч байж болно) санаа зовоож буй асуудал.
- Таны хүүхдийн талаарх чухал мэдээллүүдийг хянаж үзэх болно.
- Боломжтой байгаа эрүүл мэндтэй холбоотой бүх мэдээллийг авч үзнэ.
- Эцэг эхийн санал бодол, байр суурийг сонсож, харгалзан үздэг.

Ямар шийдвэр гаргадаг вэ?

Баг дараах саналуудыг гаргаж болно:

- Интервенц Төлөвлөгөө Боловсруулах (Интервенц Төлөвлөгөөний тухай дэлгэрэнгүйг [*APS Student Support Manual \(AUC-н Сурагч Дэмжих\) Гарын Авлагаас*](#) үзнэ үү)
- [Section 504 заалтын дагуу эрх үүсэх эсэхийг харгалзаж үзэх](#)
- [Тусгай боловсролын үнэлгээ](#) хийлгэх санал илгээх

Хэрэв баг үнэлгээ хийхийг санал болговол та:

- Зөвшөөрч, зөвшөөрөл өгнө. Таны хүүхдийг сургуулийн шаардлага хангасан мэргэжилтнүүд үнэлнэ. Үнэлгээгээр таны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй байж болох бүх талыг харгалзаж үзэх болно. Үүнд таны хүүхдийн хэрэгцээ шаардлагаас хамааран эрүүл мэнд, хараа, сонсгол, нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил, сэтгэн бодох болон суралцах чадвар, хичээлийн гүйцэтгэл, харилцаа холбоо, хөдөлгөөн, өдөр тутмын амьдралын ур чадвар багтаж болно. Үнэлгээний зарим хэсэгт нийгэм соёл, сэтгэл зүй, боловсрол, багшийн ажиглалт, шаардлагатай бол яриа/хэл, хөдөлмөрийн эмчилгээ гэх мэт бусад үнэлгээг багтааж болно.
- Татгалзах, зөвшөөрөл олгохгүй байх. Тусгай боловсролын үнэлгээг явуулахгүй.

Эцэг эх/асран хамгаалагчийн үүрэг роль юу вэ?

- Та SST-ийн тэгш эрхтэй гишүүн гэдгээ санаарай. Таны оруулсан хувь нэмэр үнэ цэнэтэй бөгөөд чухал юм. Уулзалтын үеэр хэлэлцүүлэгт идэвхтэй оролцоорой. Жич: *Хэрэв танд хэлмэрч ба/эсвэл уулзалтад оролцоход ADA хөнгөлөлт шаардлагатай бол энэ тухайгаа сургуульдаа мэдэгдэнэ үү.*
- Өөрийн санаа, бодол, санаа зовоосон асуудлуудаа чөлөөтэй хуваалцаж болно. Шаардлагатай бол асуулт асууж, тодруулга аваарай.
- Хэрэв баг тусгай боловсролын үнэлгээг үргэлжлүүлэхээр шийдсэн бол та зөвшөөрөл өгөх эсэхээ бодож үзээрэй.

Сурагч Дэмжих Багийн Уулзалтад бэлдэх

Уулзалтад бэлтгэлтэй, өөртөө итгэлтэй очих зарим зөвлөмж:

- ✓ Хүүхдийнхээ давуу тал болон нэмэлт тусламж хэрэгтэй байж болох чиглэлүүдийг тодорхойлох.
- ✓ Хүүхэдтэйгээ ярилцаж, сургуулийн талаарх болон сурлагад нь хамгийн тустай юу байж болох зэргийг асуух.
- ✓ Сургуулийн багтай хуваалцахыг хүссэн хувийн үнэлгээ, тайлангаа цуглуулж бэлдэх.
- ✓ Танай гэр бүлд юу хамгийн чухал вэ, мөн энэ уулзалтаар ямар зорилгод хүрнэ гэж найдаж буйгаа бодож үзээрэй. *Та дараах "Ярилцах Сэдвүүд" хүснэгтийг ашиглан өөрийн санаа бодлыг цэгцлэх боломжтой юм.*
- ✓ Уулзалтын үеэр асуухыг хүссэн асуултуудаа дараах "Асуулт" хэсэгт жагсааж бичнэ үү.
- ✓ Тусгай боловсролын үйл явцын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Эцэг Эхчүүдийн Мэдээллийн Төв (PRC)-с авна уу. Боломжтой бол тус байгууллагаас явуулдаг "Тусгай Боловсролын танилцуулга" хичээлд оролцох, эсвэл одоо онлайнаар үзээрэй! Энэ нь хэрэгтэй мэдээллээ олох шилдэг арга юм.
- ✓ Хэрэв уулзалтад хэн нэгнийг (найз, өмгөөлөгч, гэр бүл гэх мэт) оролцуулахаар төлөвлөж байгаа бол энэ тухайгаа сургуульдаа урьдчилан мэдэгдсэнээр нэмэлт зай, материал бэлтгэх боломжтой юм.



PRC онлайн
Видео Хичээлүүд

WATCH NOW

Асуух Асуултууд	Ярилцах Сэдэв /Нэмэлт Асуулт
- Манай хүүхдэд дараагийн алхмууд юу болох, эдгээр дараагийн алхмуудад бидний зүгээс хэрхэн бэлдэх вэ? - Хэрэв би уулзалтын дараагаар асуулт гарах юм уу эсвэл нэмэлт мэдээлэл хуваалцахаар бол багийн гишүүдийн хэнтэй нь холбогдвол зохимжтой вэ? - Цаашид би хүүхдэдээ гэрт нь ямар дэмжлэг үзүүлэх вэ? - Хэрэв SST Интервенц Төлөвлөгөө гаргах шийдвэрт хүрвэл тухайн Интервенц Төлөвлөгөө амжилттай байгаа эсэхийг мэдэхэд туслах мэдээллийг хэзээ хэрхэн яаж хуваалцах вэ? - Хэрэв SST тусгай боловсролын үнэлгээ явуулахаар шийдвэл: - Манай хүүхдэд хэзээ үнэлгээ хийх вэ? - Ямар үнэлгээ ашиглах, эдгээрийг хэрхэн сонгох вэ? - Хөтөлбөрийн эрх тодорхойлох уулзалтаас өмнө бид үзэж танилцах боломжтой үнэлгээний материалууд хэзээ хэрхэн бэлэн болох вэ? - Хэрэв сэтгэлзүйн үнэлгээ хийгдсэн бол би үнэлгээний үр дүнгийн талаар уулзалтаас өмнө сэтгэл зүйчтэй ярилцах боломжтой юу? - Хэрэв SST "Section 504" харгалзаж үзэх санал гаргасан нөхцөлд миний зүгээс "Section 504" Хорооны хуралд хэрхэн бэлдэх вэ?	



PRC танд туслахад бэлэн байна.
Бидэнтэй 703.228.7239 утсаар
эсвэл prc@arsva.us хаягаар
холбогдоно уу.



PEATC: Эцэг Эхийн
Эрх



AYC Сурагч
Дэмжих Гарын
Авлага



AYC "Section
504" Мэдээлэл



PEATC:
Үнэлгээний Тухай
Ойлголт



PEATC: Эрх
Тодорхойлуулах
Санал Илгээх



VDOE: Санал
Илгээх тухай
Видео